



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20/16 он 12 сарын 27 өдөр

Дугаар 3Г-1245

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



Ж.ЭРДЭНЭБАТ

001081



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2016 он 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар ХЭГ/2241

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт үүгээр хүргүүлж байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ


002466

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 61 дүгээр тэмдэглэлд:

“ХХИ.ХЭЛЭЛЦСЭН нь: “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Төрөөс төмөр замын тээврийн талаар
баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг
хангах тухай

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.114-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн царигтай барьж байгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/-нд үүрэг болгосугай.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mjia.gov.mn,
<http://www.mjia.gov.mn>


2016.12.23 № 1-1/2173

танай 2016.12.22-ны № 01/2297 -т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Д.ГАНБАТ ТАНАА**

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг үндэслэн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

САЙД



С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД

Д.ГАНБАТ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

**“ТӨРӨЭС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн боловсруулсан болно.

Мөн үзэл баримтлалыг боловсруулахдаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2008 оны 7/07 дугаар зөвлөмжийг удирдлага болгосон болно.

Практик шаардлага

Манай орны эдийн засагт уул уурхайн салбарын оролцоо өндөр боловч экспортын зах зээлд үнийн ба үнийн бус хүчин зүйлсээс шалтгаалан өрсөлдөх чадвар төдийлөн сайн биш байна. Монгол Улс далайд гарцгүй, дэд бүтэц, тэр дундаа төмөр замын сүлжээ, нэвтрүүлэх чадвар сул байгаа нь үүний нэг том шалтгаан болж байна.

Нүүрс, төмрийн хүдрийн экспортыг дэмжих, төмөр замын дэд бүтцийн сүлжээг өргөтгөх зорилгоор Дорноговь аймгийн нутаг дахь Зүүнбаян өртөөнөөс улсын хилийн Ханги боомт хүртэлх төмөр замын төслийн урьдчилсан судалгааг хийсэн.

Монгол Улс тэрбум гаруй тонн төмрийн хүдрийн нөөцтэй бөгөөд үүний 700 орчим сая тонн нь Дархан – Сэлэнгийн бүс нутагт оршдог. 200 орчим сая тонн нь УБТЗ-ын төмөр замын сүлжээний трассын ойролцоо (трассаас хоёр тал руугаа 200 км дотор байгаа) нутаг дэвсгэрт оршдог байна. Одоо байгаа “УБТЗ” ХНН-ийн төмөр замын дагуух нутаг дэвсгэрээс жилд ойролцоогоор 6 сая орчим тонн төмрийн хүдэр олборлосноос 4-5 сая тонныг нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хот дахь төмөрлөг боловсруулах цогцолбор руу илгээж байгаа тул үнийн хувьд тус улсын, тэр дундаа Бугатын зах зээлээс бүрэн хамааралтай байгаа юм.

Зах зээлийн байдал, тээвэрлэлтийн нөхцөл сайжирсан тохиолдолд төмөр замын дагуух төмрийн орд газруудаас төмрийн хүдэр нэмж олборлосноор нийлбэр дүнгээр 10-15 сая тонн төмрийн хүдрийг Бугат хот дахь төмөрлөг боловсруулах цогцолборт нийлүүлэх боломжтой тухай “Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо”-ноос мэдэгдсэн байдаг.

Зүүнбаян – Ханги чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх голлох ачаа нь төмрийн хүдэр байх боловч мөн тодорхой хэмжээний бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн тээвэрлэгдэх боломжтой.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 заалттай байх бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

1. Төмөр замын суурь бүтцийн шинэ чиглэл, төмөр замын шинээр барих шугамын царигийн өргөний хэмжээ, чиглэлийг тогтооно.
2. Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тус тус тусгасан болно.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэхталаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улс, БНХАУ-ын төмөр замын салбарын хамтын ажиллагаа эрчимжиж уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдэн тээвэрлэлтийн зардал буурч, хугацаа хэмнэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тогтвортой өсөн нэмэгдсэнээр төсвийн орлого тогтворжиж, эдийн засагт эерэг үр дагавар үзүүлнэ.

Монголын төмрийн хүдэр олборлогчдын зах зээлд хүрэх бүтээгдэхүүний өртгийг 4 ам.доллараар бууруулах боломжтой болж, ингэснээр бүтээгдэхүүн болон цаг хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, борлуулалтын хэмжээг 10 жилийн хугацаанд 4 сая тонноос 10 сая тонн хүртэл нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Мөн тус салбарын ДНБ-д эзлэх оролцооны хувь 2 хувиас 4 хувь болж, экспортод эзлэх оролцоо 9.8 хувиас 15 хувь болж нэмэгдэнэ. Мөн төмрийн хүдрийн экспортыг нэмэгдүүлснээр БНХАУ руу экспортлох коксжих нүүрсний хэмжээг 1-3 сая тонноор нэмэгдүүлэх боломжтой юм.

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам баригдсанаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн төв болох Бугат хот руу нийлүүлэх Монгол улсын экспортын түүхий эд, бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, бараа эргэлт, төмрийн хүдрийн экспортын нэгжээс олох орлого нэмэгдэж, өртөг зардал буурснаар Монгол Улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах шинэ чиглэлийн төмөр зам болох юм.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн болон тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн байх бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

Манай орны эдийн засагт уул уурхайн салбарын оролцоо өндөр боловч экспортын зах зээлд үнийн ба үнийн бус хүчин зүйлээс шалтгаалан өрсөлдөх чадвар төдийлөн сайн биш байна. Үүний нэг том шалтгаан нь Монгол Улс далайд гарцгүй, дэд бүтэц, тэр дундаа төмөр замын сүлжээ, нэвтрүүлэх чадвар сул байгаагаас үүдэж байна.

Иймд төмрийн хүдрийн экспортыг дэмжих, төмөр замын дэд бүтцийн сүлжээг өргөтгөх санаачлага болгож Дорноговь аймгийн нутаг дахь Зүүнбаян өртөөнөөс хилийн Ханги боомт хүртэлх шинэ чиглэлийн төмөр замын төслийн урьдчилсан судалгааг хийсэн юм.

Өнөөдөр Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дахь төмрийн хүдрийн ордуудаас жилдээ 4.8 сая тонн орчим төмрийн хүдэр олборлож Монгол Улсын Замын-Үүд, БНХАУ-ын хилийн Эрээн боомтоор төмөр замаар тээвэрлэж экспортод гаргаж байна. Цаашид зах зээлийн эрэлт нэмэгдсэнээр ачааны хэмжээ 10.0-15.0 сая тонн болж өсөх магадлалтай. Дээрх ачааны дийлэнх хэсэг нь Сайншандаас Эрээн хотын төмөр замын шилжүүлэн ачих байгууламжаар шилжүүлэн ачилт хийн ӨМӨЗО-ны Жининь (Улаанцав), Хөх хотын чиглэлээр тээвэрлэгдэн Бугат хот хүртэл 908 км тээвэрлэгддэг.

Хэрэв Дорноговь аймгийн нутаг дахь Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамыг үргэлжлүүлэн Монгол Улс, БНХАУ-ын хилийн Ханги-Мандал боомт хүртэл ойролцоогоор 281 км төмөр замын суурь бүтцийг барьж Хятадын хил рүү баригдаж байгаа төмөр замтай холбосноор Сайншанд-Зүүнбаян-Ханги-Мандал-Бугат чиглэлд тээвэрлэлтийн зай 590 км болж 318 км-ээр дөт болох юм.


Зүүнбаян-Хангийн чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх голлох ачаа нь төмрийн хүдэр байх боловч мөн тодорхой хэмжээний бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн тээвэрлэгдэх боломжтой. Үүнд:

Тус төмөр замаар 150.0 сая тонн орчим батлагдсан нөөцтэй Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дэх ордуудаас жилд коксжих нүүрс 2.0-4.0 сая тонн, зэсийн баяжмал 0.3-0.5 сая тонн, мөн БНХАУ-ын Бугат хот руу ОХУ-аас транзитаар тээвэрлэгдэх боломжтой 1.0-6.0 сая тонн нефть, 1.0 сая тонн мод, Ханги боомтоор БНХАУ-д экспортлогдож байгаа 1.5 сая тонн ачаа, УБТЗ-ийн сүлжээгээр дамжин Бугат, Хөх хотын бүс рүү нийлүүлэгдэж байгаа 1.0 сая орчим тонн ачаа бараа, Бугат-Зүүнбаян чиглэлд тээвэрлэх 1.0-2.0 сая тонн барилгын материал, металл хийц, нефтийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, хүнд машин механизм зэрэг бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх боломжтой юм.

Ийнхүү 2018 оноос 2025 онуудад жилд тээвэрлэх ачааны хэмжээг 10.4-21.2 сая тонн, 2026 оноос 2046 онуудад тээвэрлэх ачааны хэмжээг 21.2 сая тонн гэж авч үзэхэд тус чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх ачааны доод хэмжээ дундажаар 15.0 сая тоннд хүрч байгаа тул Зүүнбаян-Ханги-Мандал-Бугат чиглэлд төмөр замын сүлжээ байгуулах ачаа тээврийн үндэслэл байна гэж үзлээ.

Ачаа тээврийн хэмжээний таамаглал

	Босоо тэнхлэгийн төмөр замын ачаа тээвэрлэлтэд оролцооны хувь	УБТЗ-ын жишиг тариф	Тээвэрлэх зай, км	УБТЗ тээвэрлэж буй ачаа, сая тонн			Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар тээвэрлэх ачаа, сая тонн									
				2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025		
1.Зүүнбаян-Бугат төмөр замын ачаа тээвэр		\$/тн. км	281													
Бугатад нийлүүлэх төмрийн хүдэр	100%	0.016	281	4.5	4	3	4	5	6	7	8	9	10	10		
Бугатад Ханги боомтоор дамжин нийлүүлэх нүүрс	100%	0.018	281	0.1	0.1	0.2	2	3	3	4	4	4	4	4		
Цагаан суваргын зэс молибден	100%	0.021	281				0.2	0.3	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5		
Газрын тос	70%	0.016	281	0.07	0.06	0.06	0.05	0.05	0.05	0.05	0.05	0.05	0.05	0.05		
Транзит газрын тос	50%	0.014	281	1	2	3	2	3	3	3	3	3	3	3		
Цайрын исэл	50%	0.012	281	0.13	0.1	0.1	0.05	0.05	0.05	0.05	0.05	0.05	0.05	0.05		
Транзит мод	50%	0.016	281	1	1.5	2	1	1	1	1	1	1	1	1		
Хайлуур жонш	67%	0.019	281	0.15	0.15	0.15	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1		
Бусад	40%	0.015	281	1	1	1	0.5	0.6	0.7	0.8	0.9	1	1	1		
Нийт				7.95	8.91	9.51	9.9	13.1	14.3	16.5	17.6	18.7	19.7	19.7		
2.Бугат-Зүүнбаян төмөр замын ачаа тээвэр	25%	0.015	281	2	2	2	0.5	0.6	0.7	0.8	0.9	1	1.25	1.5		
Нийт ачаа тээврийн хэмжээ				9.95	10.91	11.51	10.4	13.7	15.0	17.3	18.5	19.7	20.95	21.2		



Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих өртгийг Тавантолгой–Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын өртгийг жишиг болгон тооцвол ойролцоогоор 1.0 тэрбум гаруй ам.доллар шаардахаар байна.

Чиглэл	Сайншанд - Ханги - Мандал - Бугат	Сайншанд - Замын-Үүд - Эрээн - Бугат	Зөрүү
Тээвэрлэлтийн зай	590 км	908 км	318 км
Тээвэрлэх ачааны хэмжээ (жилд)	4.5 сая	4.5 сая	-
Тээвэрлэлтийн зардал (жилд)	68,4 сая ам.\$	86,6 сая ам.\$	18,1 сая ам.\$
1 тн-д ноогдох тээвэрлэлтийн өртөг	15.20 ам.\$	19.23 ам.\$	4.03 ам.\$
Давуу талууд	<ol style="list-style-type: none"> 1. Тээврийн зай 318км-ээр богиносно. 2. Тээвэрлэлтийн өртөг багасна 3. Жилд тээвэрлэх ачааны хэмжээ нэмэгдэнэ. 4. Замын-Үүд боомтын ачаалал багасна. 		

Иймд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам баригдсанаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн төв болох Бугат хот руу нийлүүлэх Монгол Улсын экспортын түүхий эд, бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, бараа эргэлт, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын экспортын нэгжээс олох орлого нэмэгдэж, өртөг, зардал буурснаар улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах шинэ чиглэлийн төмөр зам болох тул Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ**

1. Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат,
2. Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Р.Мэргэн,
3. Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Ж.Батболд,
4. Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Лхагвасүрэн,
5. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Хэрлэн,
6. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дэд захирал Б.Эрдэнэбаяр,
7. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эдийн засагч Д.Золбоо.

--- о О о ---